



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа
болон Төрийн ордонтой иргэд, зочид,
төлөөлөгчдийг танилцуулах журам
батлах тухай


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэг, Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой иргэд, зочид, төлөөлөгчдийг танилцуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дэд дарга (Э.Лхагва)-д даалгасугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 185 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Б.БААСАНДОРЖ

2025000739

Монгол Улсын Их Хурлын Ерөнхий
нарийн бичгийн даргын 2025 оны 23
дугаар сарын 12-ны өдрийн 23.....
дугаар захирамжийн захирамжийн
хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ТӨРИЙН ОРДОНТОЙ ИРГЭД, ЗОЧИД, ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, байгууллага, хуулийн этгээдийн ажилтан, алба хаагч /цаашид “иргэд” гэх/, ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч /цаашид “суралцагчид” гэх/-ийг Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцуулахад энэ журмыг баримтална.

1.2.Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцуулах /цаашид “Төрийн ордонтой танилцуулах” гэх/ арга хэмжээ дараах хөтөлбөртэй байна:

1.2.1.иргэдэд зориулсан хөтөлбөр;

1.2.2.суралцагчдад зориулсан парламентын боловсрол олгох хөтөлбөр.

1.3.Төрийн ордонтой танилцуулах үйл ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/-ын иргэд, олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгж /цаашид “Олон нийттэй харилцах нэгж” гэх/ зохион байгуулах бөгөөд ажил үүргийн хуваарийн дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслол хариуцсан нэгж, Төрийн тусгай хамгаалалтын газрын Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгж болон Тамгын газрын хуралдаан зохион байгуулах асуудал хариуцсан нэгж /цаашид “Хуралдаан зохион байгуулах нэгж” гэх/ хамтран оролцоно.

1.4.Улсын Их Хурлын гишүүн Төрийн ордонтой танилцуулах зорилгоор иргэд, зочид, төлөөлөгчдийг урих арга хэмжээнд энэ журмыг баримтална.

1.5.Төрийн ордонтой танилцах хүсэлт гаргасан иргэд, суралцагчид 12 болон түүнээс дээш настай байна.

1.6.Төрийн ордонтой танилцах иргэд, суралцагчид Монгол Улсын Төрийн ордны тухай хууль, Төрийн ордонд баримтлах дэг журам болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.7.Олон нийттэй харилцах нэгж Төрийн ордонтой танилцуулах журам, хуваарь, хөтөлбөр, холбоо барих утас, хаяг зэрэг мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст нээлттэй байршуулна.

Хоёр.Төрийн ордонтой танилцах хүсэлт гаргах, хүсэлтийг бүртгэх

2.1.Иргэд, суралцагчид /цаашид хамтад нь “хүсэлт гаргагч” гэх/ Төрийн ордонтой танилцах хүсэлтээ Олон нийттэй харилцах нэгжид хандан энэ журмын 1.7-д заасан хаягийн дагуу бичгээр гаргаж, цаг товлон.

2.2.Төрийн ордонтой танилцах хүсэлтийг дараах этгээд гаргана:

2.2.1.иргэдийг төлөөлж аль нэг иргэн нь бичгээр;

2.2.2.байгууллага, хуулийн этгээдийн төлөөллийг төлөөлж тухайн байгууллага, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан албан бичгээр;

2.2.3.суралцагчдыг төлөөлж холбогдох сургалтын байгууллагын эрх бүхий албан тушаалтан албан бичгээр, эсхүл анги удирдсан багш, асран хамгаалагч бичгээр.

2.3.Төрийн ордонтой танилцах хүсэлтэд дараах мэдээллийг тусгаж, арга хэмжээ зохион байгуулахаас ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө Олон нийттэй харилцах нэгжид ирүүлнэ:

2.3.1.хүсэлт гаргагчийн талаарх мэдээлэл, Төрийн ордонтой танилцах хүний тоо, танилцах он, сар, өдөр, холбоо барих мэдээлэл;

2.3.2.хүсэлтэд дараах мэдээллийг үнэн, зөв бүрдүүлж хавсаргасан байх:

2.3.2.1.Төрийн ордонтой танилцах хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, эсхүл иргэний бүртгэлийн дугаар, хэрэв гадаад улсын иргэн, зочин, төлөөлөгч бол гадаад паспортын дугаар;

2.3.2.2.Төрийн ордонд гэрэл зургийн аппараттай нэвтрэх бол нэр, загвар, тоо.

2.4.Улсын Их Хурлын гишүүн Төрийн ордонтой танилцуулахаар урьсан иргэд, зочид, төлөөлөгчидтэй уулзалт хийх, зоог барих, гэрэл зураг авхуулах бол энэ тухайгаа хүсэлтдээ тодорхой тусгасан байна.

2.5.Олон нийттэй харилцах нэгж энэ журмын 2.3-т заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч бүртгэн, Төрийн ордонтой танилцуулах хуваарь гаргана.

2.6.Энэ журмын 2.2-т заасан хүсэлт нь энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангаагүй, мэдээлэл дутуу бол хүсэлт гаргагчид утсаар мэдэгдэж, хүсэлтийг шаардлага хангуулна. Хэрэв утсаар мэдэгдэх боломжгүй бол ирүүлсэн хаягаар хүсэлтийг буцаана.

2.7.Иргэд, суралцагчдыг Төрийн ёслол хүндэтгэлийн танхимд нэвтрүүлэх зөвшөөрлийг Олон нийттэй харилцах нэгжийн ажилтан Төрийн ёслол хариуцсан нэгжээс авах бөгөөд энэ журмын 2.5-д заасан хуваарьт өөрчлөлт оруулахгүй.

2.8.Олон нийттэй харилцах нэгжийн ажилтан энэ журмын 2.5-д заасан хүсэлт, хуваарийг Төрийн ёслол хүндэтгэлийн танхимд нэвтрүүлэх зөвшөөрлийн хамт Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээг зохион байгуулахаас ажлын нэг өдрийн өмнө Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгжид хүргүүлнэ.

2.9.Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээ хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хойшилсон бол Олон нийттэй харилцах нэгжийн ажилтан энэ талаар хүсэлт гаргагчид тухай бүр урьдчилан мэдэгдэнэ.

Гурав.Төрийн ордонд нэвтрүүлэх

3.1.Олон нийттэй харилцах нэгжийн ажилтан, Улсын Их Хурлын гишүүний урилгаар хийж байгаа арга хэмжээний хувьд тухайн Улсын Их Хурлын гишүүний туслах, Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгжийн алба хаагч Төрийн ордонтой танилцах хүсэлт гаргагчид энэ журмыг танилцуулж, мөрдүүлнэ.

3.2.Хүсэлт гаргагчид хуваарьт өдрийн товлосон цагаас 10 минутын өмнө Төрийн ордны урд хэсэгт байрлах хүндэтгэлийн шатны дэргэд цугларч, Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгжид мэдэгдэх бөгөөд хүсэлт гаргагчдыг Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасан журмын дагуу Төрийн ордонд нэвтрүүлнэ.

3.3.Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгж Төрийн ордонтой танилцах хүсэлт гаргагчдыг хуваарийн дагуу иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг (гадаад паспорт, иргэний үнэмлэхийн лавлагаа), 16 насанд хүрээгүй хүүхдийн тухайд төрсний гэрчилгээг үндэслэн, нэрсийг тулгаж, аюулгүйн үзлэг хийж, Төрийн ордонд нэвтрүүлэх бөгөөд хяналт тавьж ажиллана.

3.4.Хүсэлт гаргагч Төрийн ордонд нэвтрэхдээ гэрэл зургийн аппаратаас бусад гар утас, дуу, дүрсний бичлэгийн төхөөрөмжийг Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгжийн заасан хяналтын цэгт үлдээж, хадгалуулна. Хэрэв гэрэл зургийн аппарат байхгүй бол хоёр хүртэлх гар утастай орж болно.

3.5.Хүсэлт гаргагч Төрийн ордонд энгийн, чөлөөт хувцастай нэвтэрч болно.

Дөрөв.Төрийн ордонтой танилцуулах

4.1.Олон нийттэй харилцах нэгжийн ажилтан хүсэлт гаргагчдад Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордны түүх болон парламентын боловсролын талаар танилцуулж, хөтөч хийнэ.

4.2.Суралцагчдад зориулсан парламентын боловсрол олгох арга хэмжээг өдөрт дөрвөөс илүүгүй удаа, иргэдэд зориулсан Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээг өдөрт 16-аас илүүгүй удаа зохион байгуулах бөгөөд нэг удаа нэвтрүүлэх хүний тоо 40-өөс хэтрэхгүй байна.

4.3.Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээг энэ журмын хавсралтад заасан цагийн хуваарь, хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

4.4.Олон нийттэй харилцах нэгжийн ажилтан хүсэлт гаргагчдыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэг, хэлэлцэж байгаа асуудлын агуулгаас шалтгаалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны "Их хуралдай" танхимд гуравдугаар давхраар нэвтрүүлэх асуудлыг Хуралдаан зохион байгуулах нэгжтэй тухай бүр зөвшилцөж, шийдвэрлэнэ.

4.5.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны "Их хуралдай" танхим, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байгаа хүсэлт гаргагчид тус танхимд байх хугацаа 5 хүртэл минут байна.

4.6.Дотоод, гадаадын өндөр, дээд түвшний зочид, төлөөлөгчдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимын хоёрдугаар давхраар нэвтрүүлэх, гэрэл зураг авхуулах асуудлыг Олон нийттэй харилцах нэгж Төрийн ёслол,

Хуралдаан зохион байгуулах болон Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгжтэй урьдчилан зөвшилцөж, шийдвэрлэнэ.

4.7.Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээг Бямба, Ням, Даваа гараг, нийтээр тэмдэглэх баярын өдөр болон жил бүрийн 08 дугаар сарын 01-нээс 31-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулахгүй.

4.8.Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээг дараах тохиолдолд түр хугацаанд зогсооно:

4.8.1.Төрийн ордонд гадаад улсын өндөр, дээд түвшний айлчлал, төрийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулагдаж байгаа;

4.8.2.төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр онцгой байдал тогтоосон, олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан болж байгаа;

4.8.3.Төрийн ордонд засвар, үйлчилгээ хийгдэж байгаа болон бусад шаардлагатай тохиолдолд.

Тав.Бусад

5.1.Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнийг нэвтрүүлэхийг хориглоно.

5.2.Хүсэлт гаргагчид Төрийн ордонд нэвтрэхдээ том оврын эд зүйл болон тэсэрч дэлбэрэх, амьсгал боогдуулах, нулимс асгаруулах, хордуулах, мансууруулах болон цацраг идэвхт бодис, зэвсэг хэрэгсэл авч орохыг хориглоно.

5.3.Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээний үеэр хүсэлт гаргагчид зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг авах, дуу, дүрсний бичлэг хийх, Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээний маршрутаас бусад өрөө, танхимд нэвтрэх, зохисгүй авирлах, утаат болон электрон тамхи татах, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд саад учруулах үйлдэл гаргахыг хориглоно.

5.4.Хүсэлт гаргагч Монгол Улсын Төрийн ордны тухай хууль болон Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд заасны дагуу Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт холбогдох хууль тогтоомж, түүнийг мөрдүүлэх хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

5.5.Энэ журмыг зөрчсөн этгээдэд Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгжийн эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах эрхтэй.

“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой иргэд, зочид, төлөөлөгчдийг танилцуулах журам”-ын хавсралт



ТӨРИЙН ОРДОНТОЙ ТАНИЛЦАХ ХУВААРЬ, ХӨТӨЛБӨР

1.Иргэдэд зориулсан хөтөлбөр

Төрийн ордонтой танилцах тухай хүсэлтийг “Монгол Улс 14201, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон, Улсын Их Хурлын Тамгын газрын Иргэд, олон нийттэй харилцах газарт” гэж хаяглана. Хүсэлтийг биечлэн хүргэх бол Төрийн ордны баруун хойд хаалган дахь өргөдөл, гомдол хүлээх авах хайрцагт хийнэ.

Холбоо барих утас: 51-266452

Иргэдийг Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээг Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гарагт дараах цагийн хуваарь, хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

1.1.Цагийн хуваарь

	Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гараг				
Үдээс өмнө	09:00-09:20	09:25-09:45	09:50-10:10	10:15-10:35	10:40-11:00
	11:05-11:25	11:30-11:50	11:55-12:15	-	-
Үдээс хойш	13:30-13:50	13:55-14:15	14:20-14:40	14:45-15:05	15:10-15:30
	15:35-15:55	16:00-16:20	16:25-16:45	-	-

1.2.Хөтөлбөр

Арга хэмжээ	Үргэлжлэх хугацаа	Тайлбар
Иргэд товлосон цагаас 10 минутын өмнө Төрийн ордны урд хэсэгт байрлах хүндэтгэлийн шатны дэргэд цугласан байна.		Хүсэлт гаргагчид иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг (гадаад паспорт, иргэний үнэмлэхийн лавлагаа)-ийг, 16 насанд хүрээгүй хүүхдийн тухайд төрсний гэрчилгээг Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгжийн алба хаагчид шалгуулан Төрийн ордонд нэвтэрнэ.
Төрийн ёслол хүндэтгэлийн танхимд байрлах Төрийн есөн хөлт Их цагаан тугт хүндэтгэл үзүүлж, дурсгалын зураг авхуулна.	5-10 минут	Иргэд Төрийн есөн хөлт Их цагаан тугт мэхийн ёсолж, хүндэтгэл үзүүлсний дараа дурсгалын зураг авхуулна. Мэргэжлийн гэрэл зурагчинтай хамт орж болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны "Их хуралдай" танхимд гуравдугаар давхраар нэвтрэн, тус танхим, хуралдааны үйл ажиллагаатай танилцана.	5 хүртэл минут	Хөтөч Улсын Их Хурлын бүтэц, зохион байгуулалт, хууль батлах үе шат зэргийн талаарх танилцуулга хийнэ.
Төрийн ордон дахь уран зураг, урлагийн бүтээлтэй танилцана.	5 хүртэл минут	Иргэд, хуулийн этгээдийн төлөөллийн хүсэлт, цагийн хуваариас шалтгаалан уг арга хэмжээг цуцалж болно.

2.Суралцагчдад зориулсан парламентын боловсрол олгох хөтөлбөр

Ерөнхий боловсролын сургуулийн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 7-12 дугаар ангийн суралцагчдад зориулсан парламентын боловсрол олгох аяллыг Мягмар, Лхагва, Пүрэв гарагт дараах цагийн хуваарь, хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

2.1.Цагийн хуваарь

	Мягмар, Лхагва, Пүрэв гараг	
Үдээс өмнө	09:30-10:30	11:00-12:00
Үдээс хойш	13:30-14:30	15:00-16:00

2.2.Хөтөлбөр

Арга хэмжээ	Үргэлжлэх хугацаа	Тайлбар
Суралцагч, багш, асран хамгаалагчид товлосон цагаас 10 минутын өмнө Төрийн ордны урд хэсэгт байрлах хүндэтгэлийн шатны дэргэд цугласан байна.		Суралцагчид төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, эсхүл түүний цахим хуулбар, лавлагаатай ирж болно. Багш, асран хамгаалагчид иргэний үнэмлэхтэй ирнэ.
"Парламентын боловсрол" олгох хичээл Төрийн ордны хоёрдугаар давхрын "Соёмбо" кино танхимд зохион байгуулагдана.	15-20 минут	Монгол Улсын Үндсэн хууль, Улсын Их Хурал, төрийн бэлгэ тэмдэг зэрэг мэдээллийг суралцагчдад тайлбарлаж, богино хэмжээний хүүхэлдэйн кино үзүүлнэ.
Төрийн ёслол хүндэтгэлийн танхимд байрлах Төрийн есөн хөлт Их цагаан тугт хүндэтгэл үзүүлж, дурсгалын зураг авхуулна.	10-15 минут	Төрийн ордны барилгын түүх, Төрийн есөн хөлт Их цагаан тугийн танилцуулга, Их цагаан тугт хэрхэн мэхийн ёсолж, хүндэтгэл үзүүлэх талаар тайлбар хийнэ. Мэргэжлийн гэрэл зурагчинтай хамт орж болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны "Их хуралдай" танхимд гуравдугаар давхраар нэвтрэн тус танхим, хуралдааны үйл ажиллагаатай танилцана.	5-10 минут	Улсын Их Хурлын бүтэц, зохион байгуулалт, хууль батлах үе шат зэргийн талаарх танилцуулга хийнэ.
Төрийн ордон дахь уран зураг, урлагийн бүтээлтэй танилцана.	10-15 минут	"Хан төрийн долоон эрдэнэ" уран зураг, Их эзэн Чингис хааны алтан хөшөөний талаарх танилцуулга хийнэ.

---oOo---